

**Захиргааны хэм хэмжээний актын улмаас
зөрчигдөж болзошгүй эрхийг хамгаалсан
шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ***

УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ДЭРГЭДЭХ
ШҮҮХИЙН СУРГАЛТ СУДАЛГАА
МЭДЭЭЛЛИЙН АКАДЕМИ*

* Энэхүү дүн шинжилгээ нь Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академийн цахим хуудаст 2026 оны 02 дугаар сарын 26-ны өдөр нийтлэгдсэн болно.

* Энэхүү шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээг Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академийн Шүүхийн судалгааны төвийн дарга Б.Дөлгөөн (Ph.D) удирдаж, Захиргааны эрх зүйн секторын судлаач П.Чинунар гүйцэтгэсэн болно.



УДИРТГАЛ

Захиргааны хэм хэмжээний акт (цаашид "ЗХХА" гэх) гэж хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллагаас нийтээр заавал дагаж мөрдүүлэхээр гаргасан, гадагш чиглэсэн, үйлчлэл нь байнга давтагдах шинжтэй шийдвэрийг ойлгоно.¹

ЗХХА-д хяналт хэрэгжүүлэх хоёр үндсэн хэлбэр байдаг. Нэгдүгээрт, "объектив буюу урьдчилсан хяналт"-ын хэлбэр буюу энэ нь захиргааны байгууллага өөрөө (ихэвчлэн хууль зүйн асуудал эрхэлсэн яам) эсхүл хууль тогтоогч (эрхээ шилжүүлсэн этгээд) тухайн хэм хэмжээний актыг хүчин төгөлдөр болж мөрдөхөөс өмнө хуульд заасан нөхцөл шаардлагыг хангаж буй эсэхийг шалгаж, бүртгэдэг хэлбэр юм. Нөгөө нь "субъектив хяналт" буюу тодорхой хяналт юм.² Энэ нь иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн эсэхийг шүүхээс тодорхой нэхэмжлэлд үндэслэн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх замаар хэрэгжүүлдэг. Захиргааны байгууллагаас хэрэгжүүлэх урьдчилсан хяналтыг Захиргааны ерөнхий хууль³ (цаашид "ЗЕХ" гэх)-ийн 61-67 дугаар зүйлд тусгасан бол шүүхээс хэрэгжүүлэх урьдчилсан хяналтыг⁴ Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль⁵ (цаашид "ЗХШХШТХ" гэх)-д тусгажээ.

Энэхүү дүн шинжилгээг хийхээр сонгон авсан Улсын дээд шүүх (цаашид "УДШ" гэх)-ийн тогтоолд ЗХХА-ын хэрэгжилтийн улмаас иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөж болзошгүй гэж үзэн урьдчилан хамгаалсан байна.

Монгол Улсад 2015 оноос хэрэгжиж эхэлсэн ЗЕХ болон 2016 оны ЗХШХШТХ-ийн шинэчилсэн найруулгаар "зөрчигдөж болзошгүй эрх"-ээ хамгаалуулахаар шүүхэд хандах эрхийг нээж өгсөн нь эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх тогтолцоог бүрдүүлжээ.

Уг дүн шинжилгээгээр шүүх "зөрчигдөж болзошгүй эрх"-ийг "зөрчигдсөн эрх"-ээс хэрхэн ялгаж, хамгаалж буй чиг хандлага, практикийг судалж, тодорхойлохын зэрэгцээ, уг ойлголтыг хуульчилсан ХБНГУ-ын хэм хэмжээний актын урьдчилсан хяналтын эрх зүйн хөгжлийг харьцуулан авч үзлээ.

НЭГ. ТАНИЛЦУУЛАХ ХЭСЭГ

Шүүхийн шийдвэрийн дугаар: 001/ХТ2022/0030⁶

Шүүхийн шийдвэрийн огноо: 2022 оны 05 дугаар сарын 23-ны өдөр

Шийдвэрийн төлөв: Давж заалдах шатны шүүхийн магадлалд өөрчлөлт

¹ Захиргааны ерөнхий хууль (2015)-ийн 59 дүгээр зүйлийн 59.1 дэх хэсэг.

² Цэндийн Цогт "Захиргааны хэм хэмжээний акт", legaldata.mn, 2016, 2 дахь тал, (Сүүлд үзсэн: 2025.08.19).

³ Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2015 он, №28.

⁴ Судалгааны хүрээнд захиргааны актыг түдгэлзүүлэхтэй холбоотой урьдчилсан хамгаалалтын тухай ойлголт хамаарахгүй.

⁵ Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2016 он, №09.

⁶ Улсын дээд шүүхийн тогтоолыг бүрэн эхээр үзэх холбоос: https://shuukh.mn/single-case/3029?start_date=&end_date=&id=3&court_cat=3&bb=1 (Сүүлд үзсэн: 2025.06.10).



оруулж, нэхэмжлэгчийн хяналтын журмаар гаргасан гомдлын шаардлагын зарим хэсгийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэжээ.

Хэргийн тухай товч: Нэхэмжлэгч нь өмгөөлөл, хууль зүйн туслалцааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бөгөөд цаашид үнэт цаасны зах зээлд оролцогчдод хууль зүйн зөвлөгөө өгөн ажиллах хүсэлтэй байв. Гэтэл Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 225 дугаар тогтоолын хавсралтаар "Үнэт цаасны бүртгэлийн журам" батлагдаж, 2021 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн бөгөөд уг журмын 11 дүгээр зүйлийн 11.4.1,⁷ 11.20,⁸ 11.21⁹ дэх заалтуудад үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх этгээдэд тавих зарим шаардлагыг тусгасан байна. Нэхэмжлэгч эдээр тавьсан шаардлагууд нь биелэгдэх боломжгүй, ялгаварласан, илт хууль зөрчсөн, аль нэг аж ахуй эрхлэгчид давуу байдал олгосон, шинээр байгуулагдсан нөхөрлөлийн үйл ажиллагааг хязгаарласан гэх үндэслэлээр журмын дээрх заалтуудыг хүчингүй болгуулах нэхэмжлэл гаргажээ.

ХОЁР. ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛ

Давж заалдах шатны шүүх:¹⁰ Нэхэмжлэгчээс хүчингүй болгуулахаар маргаж буй Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 225 дугаартай тогтоолын Хавсралтаар батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 11 дүгээр зүйлийн 11.4.1, 11.20, 11.21 дэх заалтуудын улмаас нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол нь шууд хөндөгдсөн болох нь нотлох баримтуудаар тогтоогдохгүй байна гэж үзэв. Нэхэмжлэгч нь үнэт цаас гаргагчийн бүртгэлд өөрчлөлт оруулах буюу хувьцаа гаргахтай холбоотой зөвшөөрөл аваагүй учир маргаан бүхий заалтууд түүнд шууд үйлчлэхгүй гэж дүгнээд журмын холбогдох заалтуудыг хүчингүй болгох хууль зүйн үндэслэлгүй гэж шийдвэрлэжээ.

Хяналтын шатны шүүх: УДШ-ээс нэхэмжлэгчийн гаргасан нэхэмжлэлийн шаардлагад хамаарах "Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 225 дугаартай тогтоолын хавсралтаар батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 11 дүгээр зүйлийн 11.4.1 дэх заалтыг хүчингүй болгуулах шаардлага гаргасныг хэрэгсэхгүй болгосон давж заалдах шатны шүүхийн шийдэл зөв гэж дүгнээд, журмын 11 дүгээр зүйлийн 11.20, 11.21 дэх заалтууд

⁷ Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 225 дугаар тогтоол, **Үнэт цаасны бүртгэлийн журмын 11 дүгээр зүйлийн 4.1 дэх заалт**, "Хууль зүйн зөвлөгөө үзүүлэх үйл ажиллагааг 2-оос дээш жил эрхэлсэн байх"

⁸ Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 225 дугаар тогтоол, **Үнэт цаасны бүртгэлийн журмын 11 дүгээр зүйлийн 11.20 дэх заалт**, "Хороонд бүртгүүлснээс хойш 3-аас доошгүй жилийн хугацаанд үйл ажиллагаа явуулсан, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн мэргэших сургалтад хамрагдсан 2-оос доошгүй мэргэжилтэнтэй, эсхүл Хороонд бүртгэлтэй олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хууль, аудитын компани нь нийтэд санал болгон анх удаа болон нэмж хувьцаа гаргаж буй үнэт цаас гаргагчид үйлчилгээ үзүүлнэ"

⁹ Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 225 дугаар тогтоол, **Үнэт цаасны бүртгэлийн журмын 11 дүгээр зүйлийн 11.21 дэх заалт**, "Хороонд бүртгүүлснээс хойш 1-ээс доошгүй жилийн хугацаанд үйл ажиллагаа явуулсан, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн мэргэших сургалтад хамрагдсан 1-ээс доошгүй мэргэжилтэнтэй, эсхүл Хороонд бүртгэлтэй олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хууль, аудитын компани нь үнэт цаас гаргагчийн бүртгэлд өөрчлөлт оруулахтай холбоотой үйлчилгээ үзүүлнэ"

¹⁰ Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2022 оны 03 сарын 01 өдрийн 221/ШШ2022/003 дугаар магадлал, https://shuukh.mn/single_case/7829?start_date=&end_date=&id=2&court_cat=3&bb=1. (Сүүлд үзсэн: 2025.04.07).



нь нэхэмжлэгчийн "хууль ёсны эрх, ашиг сонирхлыг зөрчиж болзошгүй" гэж урьдчилсан хяналтын хүрээнд ЗХХА-г хууль ёсны эсэхэд дүгнэлт өгөхдөө дараах үндэслэл бүхий тайлбарыг хийжээ. Үүнд:

1. ... аливаа этгээдээс захиргааны хэм хэмжээний актыг хүчингүй болгуулахаар шүүхэд маргаж буй тохиолдолд нэгдүгээрт, тухайн хэм хэмжээний акт нь хүчин төгөлдөр үйлчилж буй хуульд нийцээгүй байхын зэрэгцээ, хоёрдугаарт, тухайн маргаж буй этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй бол шүүх нэхэмжлэлийг хангах зохицуулалттай. (22) ¹¹

2. Захиргааны ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.1-д заасан захиргааны актын хувьд тодорхой этгээдэд хаяглагдаж шууд эрх зүйн үр дагавар үүсгэж байдаг бол мөн хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-д заасан захиргааны хэм хэмжээний акт (үүний зэрэгцээ мөн хуулийн 73 дугаар зүйлийн 73.1-д заасан төлөвлөлтийн адил) нь тодорхой этгээдэд шууд хаяглаж чиглэдэггүй, байнга давтагдах шинжээрээ эрх зүйн үр дагавар нь харилцаанд орсон тохиолдолд илэрдэг тул уг харилцаанд орж эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн төдийгүй тухайн харилцаанд орж, эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдөж болзошгүй этгээдэд шүүхээс "урьдчилсан хамгаалалт (хяналт)" хийх зорилгоор нэхэмжлэл гаргах эрхийг хууль тогтоогч захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тусгай журмаар баталгаажуулжээ. (23)

3. Нэхэмжлэгчээс... "эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөж болзошгүй" гэх үндэслэлээр нэхэмжлэл гаргасан байхад давж заалдах шатны шүүх энэ талаар... эрх, хууль ёсны ашиг сонирхол нь шууд хөндөгдсөн болох нь нотлох баримтуудаар тогтоогдохгүй байна..." гэж дүгнэсэн нь үндэслэлгүй, шүүх "урьдчилсан хяналт"-ын хүрээнд захиргааны хэм хэмжээний актын "хууль ёсны" эсэхэд дүгнэлт өгөх нь зүйтэй. (24)

4. Хууль, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон акт нь аливаа этгээдэд тодорхой зан үйл хийхийг зөвшөөрөх, давуу байдал, эрх олгох, эсхүл зан үйл хийхийг болон хийхээс татгалзахыг үүрэг болгож, зөрчсөн бол хариуцлага хүлээлгэх зэрэг эрх зүйн үр дагавар үүсгэдэг тул тухайн хэм хэмжээгээр тодорхойлсон эрх зүйн харилцаанд оролцогч этгээд (дүгнэлт хийх чадвартай ердийн дундаж хүн)-д "тодорхой", "ойлгомжтой", "хоёрдмол утгагүй" байх нь эрх зүйн наад захын хэлбэрийн буюу формал шаардлага юм. (38)

Дээрх үндэслэлүүдээр маргаан бүхий журмын 11 дүгээр зүйлийн 11.20, 11.21 дэх заалтуудын улмаас нэхэмжлэгчийн хууль ёсны эрх, ашиг сонирхол зөрчигдөж болзошгүй" гэж үзэн захиргааны байгууллагаас алдаагаа залруулж, хуульд нийцүүлэн дахин шинэ акт гаргах хүртэл 6 сарын хугацаагаар түдгэлзүүлж, нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангах нь зүйтэй гэж шүүх бүрэлдэхүүн дүгнэжээ.

Хяналтын шатны шүүх уг тогтоолоор дараах 2 ач холбогдол бүхий дүгнэлт хийсэн байна.

¹¹ () хаалтад бичигдсэн дугаарлалт нь шүүхийн эх шийдвэрийн цогцолборын дугаар болно.

Нэгдүгээрт: Уг журмын холбогдох заалтууд нь "тодорхой, ойлгомжтой, хоёрдмол утгагүй байх" зарчмыг хангаагүй гэж дүгнэн хэм хэмжээний актын холбогдох хэсгийг түдгэлзүүлж шийдвэрлэсэн нь ЗЕХ-ийн 60 дугаар зүйлд заасан хэм хэмжээний актад тавигдах шаардлагыг илүү өргөн хүрээнд тайлбарлаж, ЗХХА хуульд нийцэхээс гадна "хуульд тавигдах наад захын хэлбэрийн шаардлагыг хангах ёстой" гэсэн байр суурь илэрхийлжээ.

Хоёрдугаарт "... нэхэмжлэгч эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөж болзошгүй гэх үндэслэлээр нэхэмжлэл гаргасан байхад, ... шүүх "урьдчилсан хяналт"-ын хүрээнд тухайн актын "хууль ёсны" эсэхэд дүгнэлт өгөх нь зүйтэй ..." гэж дүгнэсэн байна. Энэхүү шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээгээр ЗХХА-ын улмаас "зөрчигдөж болзошгүй эрх"-ийг урьдчилан хамгаалах зарчим, ойлголтын талаар голчлон судална.

ГУРАВ. ДҮН ШИНЖИЛГЭЭ

3.1. Эрх зүйн зохицуулалт болон онолын ойлголт

А. Хэм хэмжээний актад шүүхээс хяналт хийх онолын үндэслэл

Хэм хэмжээний актын хяналт (гер. *normenkontrolle*) гэдэг нь тодорхой нэг эрх зүйн хэм хэмжээ нь түүний дээд түвшний хуультай нийцэж байгаа эсэхийг шалгаж, уг хэм хэмжээ хүчин төгөлдөр эсэх, эсвэл тухайн хэм хэмжээг тодорхой хэрэгт хэрэглэж болох эсэхийг тогтоох үйл явцыг хэлнэ.¹² Энэхүү хяналт нь эрх зүйн шаталсан тогтолцооны онол (гер. *Lehre vom Stufenbau der Rechtsordnung*)-оос логик үндэслэлтэйгээр урган гардаг. Ханс Кельзен (Hans Kelsen) болон Адольф Меркл (Adolf Merkel) нарын хөгжүүлсэн уг онолын дагуу эрх зүйн бүх хэм хэмжээ нь түүнийг дээрээс тодорхойлсон суурь нормоос шууд хамааралтай бөгөөд дээд хэм хэмжээнд харшлах доод акт нь хуулийн хувьд хүчин төгөлдөр бусад тооцогдоно.

Иймээс шүүхийн хяналт нь зөвхөн маргаан шийдвэрлэх үйл ажиллагаа бус, эрх зүйн тогтвортой байдал, хууль дээдлэх зарчмын баталгаа болдог. Нөгөөтээгүүр шүүх нь зөвхөн дээд эрэмбийн хуульд нийцсэн, хүчин төгөлдөр хэм хэмжээний актад л захирагдаж, Үндсэн хууль болон хуулийг зөрчсөн аливаа хэм хэмжээний актыг удирдлага болгохгүй гэх агуулгатай. Иймд хэм хэмжээний акт дээд хуульд нийцэж байгаа эсэхийг шалгах, дээд хэм хэмжээ нь доод шатанд бүрэн хэрэгжих нөхцөлийг хангах нь бүх шатны шүүхийн үүрэг бөгөөд үүнийг объектив хяналтын нэг хэлбэр гэж үзэж болно.¹³

Орчин үед ээдрээ төвөгтэй, олон талт захиргааны үйл ажиллагаанд ЗХХА нь захиргааны зорилтыг хангахад ашиглагдах гол арга хэрэгсэл болсныг харгалзан үзвэл, хэм хэмжээний актад шүүх хяналт тавих нь эрх зүйн тогтвортой, тодорхой байдлыг хангахын зэрэгцээ захиргааны үйл ажиллагааны үр нөлөө (*Effektivität*) болон нэгдмэл байдлыг (*Gleichmäßigkeit*) дэмжих ач холбогдолтой. Ялангуяа хэм хэмжээний актын хяналт нь олон тооны хувь хүн рүү чиглэсэн захиргааны

12. 강지웅, "행정소송에서 민사소송법의 준용에 관한 연구-독일 행정소송과 우리 행정소송의 비교를 중심으로" (2023), 99, <https://s-space.snu.ac.kr/handle/10371/193660>. (Сүүлд үзсэн: 2025.11.28).

13. 강지웅, *supra* note 13, 100.



шийдвэрүүд тус бүрд нь нэхэмжлэл гаргахаас урьдчилан сэргийлдэг тул хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардлыг хэмнэхэд чухал хувь нэмэр оруулдаг. Эдгээр нөхцөл байдлыг нэгтгэн дүгнэхэд, захиргааны хэм хэмжээний актад тавих шүүхийн хяналт нь захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны объектив хяналтын хувьд онцгой ач холбогдолтой гэж үзэх боломжтой.¹⁴

Б. Үүсэл хөгжил

Анх Герман Улсын өмнөд мужууд (Бавари, Бремен, Хессен, Вюртемберг-Баден)-д хүчин төгөлдөр үйлчилж байсан Захиргааны шүүхийн тухай хууль (VGG)-д хэм хэмжээний актад хяналт тавих ажиллагааг зохицуулсан байдаг боловч бусад муж улсын хуульд ийм төрлийн маргааныг хүлээн зөвшөөрдөг зохицуулалт байсангүй. 1960 онд "Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль"¹⁵ (цаашид "VwGO" гэх) батлагдахад хэм хэмжээний актын хяналтын ажиллагааны эрх зүйн үндсийг бий болгосон ч, уг тогтолцоог нэвтрүүлэх эсэхийг тухайн муж улсын сонголтод үлдээжээ.¹⁶

Хууль тогтоогчийн тайлбар бичиг (1958)-т хэм хэмжээний актын шүүхийн хяналтын зорилгыг "нэг шийдвэрээр олон ижил төрлийн маргааныг урьдчилан хааж, тухайн хэм хэмжээний актын хууль ёсны байдалд нэгдсэн дүгнэлт гаргах" гэж тодорхойлсон байдаг. Мөн уг хяналт нь Үндсэн хуулийн шүүхийн бүрэн эрхтэй давхцахгүй, харин захиргааны шүүхийн хүрээнд хэрэгжих иргэнд чиглэсэн шүүхийн хамгаалалт байх ёстой гэж тодорхойлсон байдаг.¹⁷ VwGO-ын анхны хувилбарт нэхэмжлэх эрхийн нарийн босго байгаагүй бөгөөд "тухайн хэм хэмжээний актаас сөрөг үр дагавар хүлээсэн" гэж үзвэл шүүхэд хандах боломжтой байсан байна. Энэ нь субъектив эрхийн хяналтаас илүү объектив хууль ёсны байдлыг шалгах шүүхийн хяналт болгон төлөвшүүлэхэд чиглэжээ. Түүнчлэн шүүхээс хэм хэмжээний актыг хууль бус гэж үзсэн тохиолдолд тухайн шийдвэрийг нийтэд ил тод зарлах ёстой гэж заасан нь шүүхийн шийдвэрийг зөвхөн тухайн хэрэгт бус, нийтэд хамаарах эрх зүйн үр дагавартай болгожээ.¹⁸

Улмаар 1976 онд хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, барилга, хот байгуулалтын төлөвлөлт (*Bebauungsplan*) зэрэгт, хэм хэмжээний шууд хяналтыг Холбооны түвшинд нэг мөр болгон зохицуулах шаардлага үүссэн тул хуулийг шинэчлэн баталсан байна. Уг нэмэлт өөрчлөлтөөр хэм хэмжээний актын хяналтын цар хүрээ өргөжиж, ирээдүйд зөрчигдөж болзошгүй эрхийг урьдчилан хамгаалах үзэл санааг хуульчилсан нь онцгой ач холбогдолтой болжээ. Тодруулбал, эрх зөрчигдөөгүй ч зөрчигдөх бодит, тодорхой эрсдэл үүссэн нөхцөлд шүүхэд хандах боломжийг нээсэн¹⁹ бөгөөд ингэснээр эрхийн хамгаалалтын хүрээ бодит

14 Ibid.

15 Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академи, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Захиргааны хэрэг шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2025.

16 Deutscher Bundestag. (1958). *Entwurf einer Verwaltungsgerichtsordnung (BT-Drs. 3/55)*, Deutscher Bundestag, <https://dserver.bundestag.de/btd/03/000/0300055.pdf>. (Сүүлд үзсэн: 2025.11.04).

17 Engelhardt, Olaf-Roman Baron von. *Der Rechtsschutz gegen Rechtsnormen*. Berlin, Deutschland: Duncker & Humblot, 1971, <https://www.duncker-humblot.de/>. (Сүүлд үзсэн: 2025.11.04).

18 Deutscher Bundestag. (1958). *Entwurf einer Verwaltungsgerichtsordnung (BT-Drs. 3/55)*, Deutscher Bundestag, <https://dserver.bundestag.de/btd/03/000/0300055.pdf>. (Сүүлд үзсэн: 2025.11.04).

19 Bundesrepublik Deutschland. (1975). *Entwurf eines Gesetzes zur Änderung verwaltungsprozessualer Vorschriften (Bundestags-Drucksache 7/4324, 21 November 1975)*, <https://dserver.bundestag.de/btd/07/043/0704324.pdf>. (Сүүлд үзсэн: 2025.11.04).



хохирлоос гадна "зөрчигдөж болзошгүй эрх"-ийг хамруулах болсон юм. Энэхүү үзэл санаа нь Герман Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан "үр нөлөөтэй эрхийн хамгаалалт"-ын зарчимтай нийцэж, захиргааны шүүхийн урьдчилсан хяналтын онолын суурийг бүрдүүлж, шүүхийн хяналтаар тухайн эрхийг хамгаалах боломжийг хуульчилсан эрх зүйн шинэчлэл болжээ.

3.2. Монгол Улсад хуульчлагдсан байдал

Монгол Улсад 2015 онд ЗЕХ батлагдсанаар ЗХХА нь захиргааны үйл ажиллагааны нэг хэлбэр болон хэлбэржсэн²⁰ бөгөөд энэ хуулиар ЗХХА гэх ойлголтыг тодорхойлж, түүнийг батлах, бүртгэх, хүчингүй болгох журам, тавигдах шаардлагыг нарийвчлан хуульчилсан нь захиргааны үйл ажиллагааг илүү ил тод, хариуцлагатай болгох алхам болсон юм. ЗХХА нь гадагш чиглэсэн, нийтээр дагаж мөрдөх шинжтэй, байнга давтагдан хэрэглэгдэх зохицуулалт тул түүний хэрэгжилт нь зөвхөн нэг этгээд бус, олон хүний эрх, хууль ёсны ашиг сонирхолд нөлөөлөх магадлалтай. Иймээс урьдчилсан хяналт буюу зөрчигдөж болзошгүй эрхийг хамгаалах механизм Монгол Улсын эрх зүйн тогтолцоонд зайлшгүй шаардлагатай гэж хууль тогтоогч үзжээ.²¹ 2016 оны 1 дүгээр сарын 1-ээс мөрдөгдөж эхэлсэн ЗХШХШТХ-ийн шинэчилсэн найруулгаар "зөрчигдсөн болон зөрчигдөж болзошгүй эрх"-ийн аль алинд нь шүүхийн хяналт үйлчлэхийг хуульчилсан нь энэ тогтолцооны эрх зүйн тулгуур болсон гэж үзэж болно.

ЗХШХШТХ-ийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг:

Энэ хуулийн зорилт нь хүн, хуулийн этгээдээс захиргааны байгууллагын хууль бус үйл ажиллагааны улмаас зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар, түүнчлэн нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд, хуульд заасан бол захиргааны байгууллагаас гаргасан нэхэмжлэлийн дагуу захиргааны хэргийг шүүхэд хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

ЗХШХШТХ-ийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь хэсэг:

"нэхэмжлэл" гэж хүн, хуулийн этгээдээс захиргааны хууль бус үйл ажиллагааны улмаас зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар, түүнчлэн нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд, хуульд тусгайлан заасан бол захиргааны байгууллагаас нийтийн эрх зүйн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдон үүссэн маргааныг шийдвэрлүүлэхээр захиргааны хэргийн шүүхэд гаргасан өргөдлийг гэж тодорхойлжээ.

Өөрөөр хэлбэл, шүүхийн хяналт нь өмнө зөрчигдсөн эрхийн хүрээнд өөрт чиглэсэн захиргааны актаар хязгаарлагдаж байсан бол ЗХШХШТХ-ийн шинэчилсэн найруулгаар энэ хүрээ тэлж, захиргааны хэм хэмжээний акт, захиргааны гэрээ, төлөвлөлт зэрэг шинэ ойлголт хуульчлагдаж, нийтийн эрх ашгийг хөндсөн асуудлаар ч нэхэмжлэл гаргах боломжтой болсон²² байна.

20 Баттулгын Дөлгөөн, Наянбаатарын Хулан, Монголын Отгондэлгэр, *Захиргааны хэм хэмжээний акттай холбоотой маргаан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн судалгаа*, (4 дүгээр бүлэг) (Улаанбаатар: Номбест, 2025), 110 дахь тал.

21 Захиргааны ерөнхий хууль (2015)-ийн үзэл баримтлал, 2 дахь тал.

22 Дугарын Сүнжид, *Захиргааны ерөнхий хууль: үзэл баримтлал, хэрэглээ*, 2017, 23 дахь тал.



Энэхүү шинэчлэл нь ХБНГУ-ын VwGO-ын §47(2)-т заасан "ойрын хугацаанд эрх нь зөрчигдөж болзошгүй этгээд шүүхэд хандах эрхтэй" гэсэн үзэл санаатай агуулгын хувьд дүйцэх бөгөөд Монгол Улсад ч "эрх зөрчигдөхөөс өмнө шүүхийн хяналт хэрэгжүүлэх" онолыг бодит практикт тусгасан явдал болжээ.

Уг дүн шинжилгээгээр авч үзэж буй УДШ-ийн тогтоолд ч энэхүү ойлголтыг баталгаажуулсан байна. Тухайлбал, "зөрчигдөж болзошгүй эрх"-ийн хүрээнд хэм хэмжээний актад шүүхээс хяналт хийхдээ "...захиргааны хэм хэмжээний акт нь олон нийтэд нэгэн зэрэг үйлчлэх шинжтэй, эрх зүйн үр дагавар нь тухайн харилцаанд орсон үед л илэрдэг онцлогтой учир иргэн тухайн харилцаанд орж эрх нь хохироогүй байсан ч хожим хохирч болзошгүй бол шүүхээс "урьдчилсан хамгаалалт (хяналт)" үзүүлэх зорилгоор шууд нэхэмжлэл гаргах эрхийг хууль тогтоогч олгосон гэж үзсэн байна"²³ гэж тайлбарлажээ.

Дээрх тайлбарт ЗХХА нь олон нийтэд чиглэсэн, байнга давтагдах шинжтэй, үр нөлөө нь тухайн харилцаанд орсон үед л илэрдэг онцлогтой тул түүний хэрэгжилт ирээдүйд иргэний эрх ашигт сөргөөр нөлөөлөх бодит эрсдэлтэй байх боломжтой. Иймд шүүхээс тухайн актыг "урьдчилан хянах" замаар нийгэмд өргөн хүрээний эрх зүйн хамгаалалт үзүүлэх нь зүйтэй гэж үзжээ.

Нэгтгэн дүгнэвэл, Монгол Улсад шүүхийн урьдчилсан хяналт нь зөвхөн эрх зөрчигдсөний дараа нөхөн сэргээх зорилготой бус, эрхийн зөрчил үүсэхээс өмнө урьдчилан сэргийлэх зорилготой хамгаалалтын механизм болон төлөвшиж байна Үүнд:

- Нэгдүгээрт, "урьдчилсан хяналт" нь тухайн акт хуульд нийцэж байгаа эсэхэд дүгнэлт өгөх үйл явц;
- Хоёрдугаарт, "урьдчилсан хамгаалалт" нь зөрчил үүсэхээс өмнө хохирол гарах магадлалыг таслан зогсоох шүүхийн шийдвэрийн нэг хэлбэр юм.

Ийнхүү Монгол Улсад "зөрчигдөж болзошгүй эрх"-ийн үзэл санааг хуульчилсан явдал нь зөвхөн шүүхийн хяналтын цар хүрээг тэлэх төдий бус, иргэний эрхийг урьдчилан хамгаалах тогтолцоог бэхжүүлсэн, Монголын захиргааны эрх зүйн хөгжлийн шинэ шат болжээ.

Захиргааны хэм хэмжээний актад холбогдуулан нэхэмжлэл гаргах

ЗХХА-ын хувьд эрх зүйн үр нөлөө нь олон нийтэд зэрэг үйлчлэх шинжтэй бөгөөд тодорхой этгээдэд шууд хаяглагддаггүй онцлогтой. Тиймээс иргэн, хуулийн этгээдийн эрх зөрчигдөөгүй байсан ч тухайн актын хэрэгжилтээс үүдэн эрх, ашиг сонирхол нь хожим хохирч болзошгүй нөхцөл байдал үүсэх магадлал байвал нэхэмжлэл гаргах эрх нь үүснэ.

ЗХХА-д холбогдуулан зөрчигдөж болзошгүй эрхээ хамгаалуулахаар нэхэмжлэл гаргах тохиолдолд иргэн, хуулийн этгээд нь ЗХШХШТХ-ийн 52 дугаар зүйлийн 52.5.6 дахь хэсэгт зааснаар нэхэмжлэгч өөрийн ямар эрх, ашиг сонирхол хэрхэн зөрчигдөж болзошгүй, мөн уг акт аль хуультай ямар зөрчилтэй байгааг тодорхой тусгах ёстойг хуульчилжээ. Харин нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах тохиолдолд дээрхээс гадна хангалттай сонирхол илэрхийлсэн

²³ УДШ-ийн 2022 оны 3 дугаар сарын 01-ний өдрийн 001/ХТ2022/0030 тогтоолын 23 дахь цогцолбор.



байх нөхцөл заасан байна.

Хүснэгт 1. ЗХШХШТХ-ийн 52 дугаар зүйлийн 52.5.6, 52.6 дахь хэсэгт заасан ЗХХА-д нэхэмжлэл гаргах үндэслэл, шаардлага

Нэхэмжлэлийн шаардлага	Захиргааны хэм хэмжээний актыг хүчингүй болгох, эсвэл хүчин төгөлдөр бус болохыг тогтоолгох
Нэхэмжлэлийн шаардлагын агуулга	Хүн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хэрхэн зөрчигдсөн, эсвэл зөрчигдөж болзошгүй байдал болон аль хуультай зөрчилдсөн болохыг тодорхой тусгасан байх
Нэхэмжлэл гаргах эрх бүхий этгээд	- Хэм хэмжээний актын үйлчлэлд өртөх иргэн, хуулийн этгээд - Нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд - Захиргааны байгууллага өөрөө (52.6)
Шүүхээс нэхэмжлэл хүлээн авах үндэслэл	- Хэм хэмжээний акт нь хууль зөрчсөн эсэх - Эрх зөрчигдөх магадлал бодит, үндэстэй эсэх - Нэхэмжлэлд дурдсан хууль зүйн үндэслэл тодорхой эсэх
Шүүхийн шийдвэрийн хэлбэр	- Хэм хэмжээний актыг хүчингүй болгох - Хүчин төгөлдөр бус гэж тогтоох - Тусгай нөхцөлд — акт батлах үүрэг биелүүлэхийг даалгах
Шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох	ЗХШХШТХ-ийн 52 дугаар зүйлийн 52.5.6-ийн дагуу гаргах ЗХХА-ыг хүчингүй болгуулах нэхэмжлэлийн зорилго нь субъектив эрхийн хяналтыг хэрэгжүүлэхэд чиглэгдэх боловч шүүхийн шийдвэр нийтэд хамааралтай байх боломжтой тул хийсвэр хяналтын шинжийг давхар агуулна. ²⁴

Дээрхээс үзвэл, шүүх нэхэмжлэлийг хүлээж авахдаа маргаж буй захиргааны акт нь нэхэмжлэгчийн эрхийг зөрчсөн болохыг тогтоож нотолсон байхыг шаардахгүй, маргаан бүхий захиргааны шийдвэр, үйл ажиллагааны улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдсөн байж болзошгүй нь, түүнчлэн зарим төрлийн нэхэмжлэлийн хувьд нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдөж болзошгүй нь нэхэмжлэлийн шаардлага, түүний үндэслэлээр тодорхойлогдож байгаа тохиолдолд "нэхэмжлэл гаргах эрх бүхий этгээд" гэж үзнэ.²⁵ Өөрөөр хэлбэл, маргаж буй захиргааны шийдвэрийн үйлчлэл нь нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд халдсан байж болзошгүй шалтгаант холбоотой байхад нэхэмжлэлийг хүлээн авах үндэслэл болохоор байна.

Шүүхэд хандах тохиолдолд захиргааны хэм хэмжээний актыг хүчингүй болгох, эсвэл хүчин төгөлдөр бус болохыг тогтоолгох нэхэмжлэлийн шаардлагаар хязгаарлагдах бөгөөд шүүхийн шийдвэр ч мөн адил ЗХШХШТХ-ийн 106 дугаар зүйлийн 106.3.8-д заасны дагуу гарна.

24 Гочоогийн Банзрагч, *Захиргааны процессын эрх зүй*, (хоёр дахь хэвлэл). (Улаанбаатар: Мөнхийн үсэг, 2023), 184 дэх тал.

25 Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдааны 2023 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 30 дугаар тогтоол, "Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим заалтыг тайлбарлах тухай", <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16760192701521>.



Хэдийгээр ЗХХА-ын хяналт нь дээрх нэхэмжлэлийн шаардлагаар хязгаарлагдах хэдий ч тухайн актыг батлан гаргах үүрэгтэй этгээд уг үүргээ биелүүлэхгүй буюу хэм хэмжээний актыг батлан гаргахгүй байгаа, үүний улмаас нийтийн ашиг сонирхол, эсхүл сонирхогч этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй нь шүүхийн журмаар тогтоогдсон тохиолдолд, тухайн эрх бүхий этгээдэд хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж, хэм хэмжээний акт батлан гаргахыг даалгах боломжтой. Энэ нь "хууль тогтоомжийг хянах эрх"-ийн агуулгад хамааралгүй гэж УДШ-ээс 2019.10.02-ны өдрийн 295 дугаар тогтоолдоо тайлбарласан байдаг. Мөн уг тогтоолд хэм хэмжээний актыг хууль бус байсан болохыг тогтоолгох нэхэмжлэлийн шаардлага гаргасныг шүүх шийдвэрлэх боломжгүй, энэ төрлийн шаардлагыг зөвхөн захиргааны актын хувьд гаргах боломжтой²⁶ гэж дүгнэжээ.

Нэмж дурдахад, захиргааны хэм хэмжээний акттай холбоотой маргааны онцлогт тохируулан хууль тогтоогч ЗХШХШТХ-ийн 112 дугаар зүйлийн 112.1.1-д заасан ЗХХА-ын хувьд тусгай журмаар хянан шийдвэрлэхээр заажээ. ЗХХА-ын хувьд зөвхөн шүүхэд нэхэмжлэл гаргаж буй этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлоор хязгаарлагдах бус тухайн актын үйлчлэлд өртөх олонхын эрх, ашгийг давхар агуулж байдаг онцлогтой. Иймд ЗХХА-ын хяналтын тогтолцоо нь иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөх, зөрчигдөж болзошгүй нөхцөл байдал үүссэн бол түргэн шуурхай шийдвэрлэхийг зорьсон, илүү үр нөлөөтэй шүүхийн хамгаалалт үзүүлэх эрх зүйн зохицуулалт болохыг харуулж байна.

3.3. Төсөөтэй шүүхийн шийдвэр

Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан /shuukh.mn/-аас "зөрчигдөж болзошгүй эрх" гэх түлхүүр үгээр хайлт хийж, энэхүү дүн шинжилгээгээр сонгон авсан УДШ-ийн тогтоолын үйл баримт, эрх зүйн харилцаатай адил төсөөтэй тайлбар хийсэн 1 тогтоолын талаар авч үзье.

УДШ-ийн 2022 оны 10 дугаар сарын 03-ны өдийн 001/ХТ2022/0056 тогтоол²⁷

Хэргийн тухай товч: Нэхэмжлэгч нь телефон ярианы болон интернэтийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг захиргааны байгууллагаас 2017 онд авсан, харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээд юм. Харилцаа холбооны зохицуулах газраас 2021 онд баталсан "Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам"-д үүрэн холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг "... сонгон шалгаруулалтаар олгох ..." гэж заажээ. Нэхэмжлэгчээс үүрэн холбооны чиглэлээр үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг зөвхөн сонгон шалгаруулалтаар олгох хэм хэмжээг тогтоосон нь хуулиар хориглоогүй асуудлаар хориглосон зохицуулалт бий болгосон үзсэн байна. Түүнчлэн дээрх журмын хууль бус зохицуулалтыг үндэслэн ... Нийслэл

26 УДШ-ийн 2019 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 295 дугаар тогтоол, https://shuukh.mn/single-case/1965?daterange=2019-10-01%20-%202019-10-04&id=3&court_cat=3&bb=1. (Сүүлд үзсэн: 2025.10.03).

27 Улсын дээд шүүхийн тогтоолыг бүрэн эхээр үзэх холбоос: https://shuukh.mn/single-case/2813?daterange=2022-01-01%20-%202022-10-30&id=3&court_cat=3&bb=1. (Сүүлд үзсэн: 2025.08.27).



дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд гаргасан нэхэмжлэлд захиргааны хэрэг үүссэн, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байгаа, уг маргааныг шийдвэрлэхэд хууль бус захиргааны хэм, хэмжээний актыг үндэслэн нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчиж болзошгүй байна гэж үзэн журмын дээрх заалтыг хүчингүй болгуулахаар тухай нэхэмжлэл гаргажээ.

Давж заалдах шатны шүүх:²⁸ Анхан шатны журмаар дээрх хэргийг хэлэлцээд журам батлах бүрэн эрх нь хариуцагчид хуулиар олгогдсон бөгөөд хууль зөрчсөн байдал тогтоогдоогүй, хариуцагч төрийн захиргааны байгууллагаас тухайн журмын дагуу олгосон тусгай зөвшөөрөл нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөөгүй гэж үзэн нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгон шийдвэрлэжээ.

Хяналтын шатны шүүх: Аливаа этгээдээс захиргааны хэм хэмжээний актыг хүчингүй болгуулахаар шүүхэд маргаж буй тохиолдолд нэгдүгээрт, тухайн хэм хэмжээний акт нь хүчин төгөлдөр үйлчилж буй хуульд нийцээгүй байхын зэрэгцээ, хоёрдугаарт, тухайн маргаж буй этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй нөхцөл байдал үүссэн бол шүүх нэхэмжлэлийг хангах зохицуулалттай.²⁹

Өөрөөр хэлбэл, Захиргааны ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.1-д заасан захиргааны актын хувьд тодорхой этгээдэд хаяглагдаж шууд эрх зүйн үр дагавар үүсгэж байдаг бол мөн хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-д заасан захиргааны хэм хэмжээний акт (үүний зэрэгцээ мөн хуулийн 73 дугаар зүйлийн 73.1-д заасан төлөвлөлтийн адил) нь тодорхой этгээдэд шууд хаяглаж чиглэдэггүй, байнга давтагдах шинжээрээ эрх зүйн үр дагавар нь тухайн эрх зүйн хэм хэмжээний зохицуулалтын харилцаанд орсон тохиолдолд илэрдэг тул уг харилцаанд орж эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн төдийгүй тухайн харилцаанд орж, эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдөж болзошгүй этгээдэд шүүхээс "урьдчилсан хамгаалалт (хяналт)" хийх зорилгоор нэхэмжлэл гаргах эрхийг хууль тогтоогч захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тусгай журмаар баталгаажуулжээ (*Улсын дээд шүүхийн захиргааны хэргийн шүүх хуралдааны 2022 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 30 дугаар тогтоолын 22–23 дугаар заалт*).³⁰

Нэхэмжлэгч ... шүүхэд гаргасан нэхэмжлэлд захиргааны хэрэг үүсгэсэн ... компанийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчиж болзошгүй ..." гэсэн үндэслэлээр маргаж, энэ хүрээнд эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөж болзошгүй гэж хэм хэмжээ тогтоосон актыг хянуулахаар хандсан байхад давж заалдах шатны шүүх "... тухайн өөрт эрх олгосон зэрэг нөлөөлөл бүхий актыг хүчингүй болгуулахаар хандсан нь ойлгомжгүйн зэрэгцээ уг актын улмаас нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөөгүй ..." гэж дүгнэсэн нь үндэслэлгүй болжээ³¹ гэж дүгнэсэн байна.

Нэгтгэн дүгнэхэд, дээрх тогтоолууд нь ЗХШХШТХ-д хуульчилсан урьдчилсан хяналт, урьдчилсан хамгаалалтын зарчмыг шүүхийн практикт бодитойгоор

28 ЗХДЗШШ-ийн 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 221/ШШ2022/0017 магадлал. https://shuukh.mn/single_case/7831?start_date=&end_date=&id=2&court_cat=3&bb=1. (Сүүлд үзсэн: 2025.08.27).

29 УДШ-ийн 2022 оны 10 дугаар сарын 03-ны өдийн 001/ХТ2022/0056 тогтоол, 4 дэх цогцолбор.

30 УДШ-ийн 2022 оны 10 дугаар сарын 03-ны өдийн 001/ХТ2022/0056 тогтоол, 5 дахь цогцолбор.

31 УДШ-ийн 2022 оны 10 дугаар сарын 03-ны өдийн 001/ХТ2022/0056 тогтоол, 7 дахь цогцолбор.



хэрэгжүүлсэн ач холбогдолтой байна. Урьдчилсан хяналт хийх нөхцөл нь иргэн, хуулийн этгээдийн зөрчигдөж болзошгүй хууль ёсны эрх, ашиг сонирхол юм.

ЗХХА-ын хувьд тодорхой хэсэг бүлэг этгээд рүү чиглэсэн, тухайн этгээд хэм хэмжээний актаар зохицуулсан харилцаанд оролцохоос өмнө (эрх зүйн үр дагавар үүсэхээс өмнө) хууль ёсны эрх, ашиг сонирхол зөрчигдөх магадлалтай гэдгийг урьдчилан мэдэх боломж бага байна. Ийм ч учраас хэм хэмжээний акттай холбогдуулан эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн эсхүл зөрчигдөж болзошгүйг тогтооход хүндрэлтэй байж болохыг дүн шинжилгээ хийж буй тогтоолуудын давж заалдах шатны шүүхийн шийдлүүдээс харж болно.

Дээрх тогтоолуудад хууль тогтоогчийн зорилго нь иргэн хуулийн этгээдийн хууль ёсны эрх, ашиг сонирхол хараахан хохироогүй байсан ч хожим хохирч болзошгүй нөхцөлд шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийг олгосон болохыг онцолж, урьдчилсан хяналтын зарчмыг тодорхойлон хэрэгжүүлсэн байна. Товчхондоо захиргааны шийдвэр нь иргэн, хуулийн этгээдэд шууд чиглээгүй байсан ч түүний үр дагавар ирээдүйд нөлөөлж болохуйц бол урьдчилан шүүхэд хандах боломжтой болох нь практик болон тогтсон байна.

Шүүхийн практикт урьдчилсан хяналт, хамгаалалтын зарчим хэрэгжихдээ иргэн, хуулийн этгээдийн ирээдүйд учирч болзошгүй хохирлыг таслан зогсоохын зэрэгцээ захиргааны байгууллагын хууль бус актын үр дагаврыг түр хугацаанд зогсоож, улмаар захиргааны байгууллагад хуульд нийцсэн шинэ зохицуулалт бий болгох боломжийг олгон нийтийн эрх ашиг болон захиргааны байгууллагын бие даасан байдлыг хадгалж, хоорондын зохистой байдлыг тэнцвэржүүлсэн шийдвэр гаргажээ.

3.4. Харьцуулсан судалгаа

ХБНГУ-ын хувьд, өмнөх онолын хэсэгт дурдсанчлан, ЗХХА-ын шүүхийн хяналт болон "эрх нь ойрын хугацаанд зөрчигдөх магадлалтай этгээд" шүүхэд өргөдөл гаргах боломжийг VwGO §47.2-т тодорхой хуульчилсан байдаг. Эдгээр зохицуулалт нь Монгол Улсын ЗХШХШТХ-д тусгагдсан "зөрчигдөж болзошгүй эрхийн хүрээнд шүүхэд хандах" эрхийн үзэл баримтлалтай суурь утгаараа нийцэх тул энэ хэсэгт ХБНГУ-ын туршлагыг харьцуулан судлах нь оновчтой гэж үзлээ.

А. ХБНГУ-д хуульчлагдсан байдал

VwGO §47-д заасан "хэм хэмжээний актын хяналт" нь нэг талаас иргэний субъектив эрхийг хамгаалах, нөгөө талаас захиргааны тогтолцооны хууль ёсны байдлыг хангах гэсэн хоёр түвшний зорилготой байдаг.³²

§47³³

(1) Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх харьяаллын хүрээнд гаргасан гомдлыг үндэслэн дараахыг хууль ёсны эсэхийг шийдвэрлэнэ.

1. Барилгын тухай хуулийн дагуу баталсан журам болон Барилгын тухай хуулийн §246.2-т үндэслэн гаргасан эрх зүйн акт

32 Schenke, W.-R. *Verwaltungsprozessrecht* (행정소송법), (강현호, Trans.), 홍지기법률연구재단 (2018), 401.

33 Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академи, өмнөх эшлэл 16, 17–18 дахь тал.



2. Муж улсын хуульд заасан бол муж улсын хуулиас доогуур эрэмбэлэгдсэн бусад эрх зүйн акт

(2) Захиргааны хэм хэмжээний акт, түүний хэрэглээний улмаас эрх нь зөрчигдсөн эсхүл ирээдүйд эрх нь зөрчигдөж болзошгүй гэж үзэж буй аливаа хувь хүн, хуулийн этгээд, түүнчлэн аливаа төрийн байгууллага эрх зүйн актыг нийтэлснээс хойш нэг жилийн дотор гомдол гаргаж болно. Гомдлыг хэм хэмжээний акт гаргасан нийтийн эрх зүйн байгууллага, санд гаргана. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх нь тухайн эрх зүйн актын үйлчлэлд хамаарах муж улс, бусад нийтийн эрх зүйн хуулийн этгээдэд заасан хугацаанд тайлбар өгөх боломжийг олгож болно. \$65.1, 65.4 болон \$66-г хэрэглэнэ.

Объектив эрхийг хамгаалах жишээг дурдвал, \$47.2-т заасан зохицуулалтын дагуу Байгаль орчныг хамгаалах тухай хууль (UmwRG) \$2.1-т тулгуурлан байгаль орчны нөлөөллийн үнэлгээний төлөвлөгөөнд эсэргүүцэл гаргах эрх бүхий байгууллагын хяналт (UmwRG §3) нь эрхийн зөрчлийг урьдчилсан нөхцөл болгодоггүй. Ийм төрлийн эрх зүйн хяналт нь цэвэр объектив эрх зүйн маргаан болно.³⁴ Энэ нь VwGO \$47-ийн дагуу хэм хэмжээний актад хийгдэх шүүхийн хяналт нь зөвхөн хувь этгээдийн эрх ашгийг хамгаалаад зогсох бус, нийтийн эрх зүйн орчны хууль ёсны байдлыг хамгаалах давхар үүрэгтэй болохыг илтгэх юм.

Б. ЗХХА-ын хяналтын хэлбэр

ХБНГУ-ын захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд, шүүгч нь тодорхой хэрэг маргааны хүрээнд урьдчилан шийдэх асуудал болгон ЗХХА хуульд нийцсэн эсэх, түүний хүчин төгөлдөр байдлыг шалгаж, тухайн хэрэгт хэрэглэх эсэхийг шийддэг "хавсарсан конкрет хэм хэмжээний хяналт"-ын тухай хуульчлаагүй ч, Үндсэн хуулийн 20 дугаар зүйлийн 3 дахь хэсэг болон шүүхийн хамгаалалтыг баталгаажуулсан 19 дүгээр зүйлийн 4 дэх хэсгээр дэмжигддэг байна.

ЗХХА-ын хяналт нь тухайн акт хүчин төгөлдөр эсэх, хуульд нийцсэн эсэхийг маргааны гол зүйл болгодог тул "шууд хяналт"-ын төрөлд багтана. Мөн тодорхой хэрэг маргаантай холбоогүйгээр нэхэмжлэгч шүүхэд өргөдөл гаргаснаар шүүхийн хяналт шууд эхэлдэг онцлогоос нь үзвэл "абстракт (хийсвэр) хяналт"-ын ангилалд орно.

Хүснэгт 2. Хэм хэмжээний актын хяналтын ангилал³⁵

1. Хэм хэмжээг шүүхээр хянах нь бие даасан маргаан болж чадах эсэхийг харгалзсан ангилал	
Хэм хэмжээний актын шууд хяналт (prinzipale Normenkontrolle)	Хяналтын объект болсон хэм хэмжээний акт хүчин төгөлдөр эсэх, хуульд нийцсэн эсэх нь шууд маргааны гол зүйл болж, үр дүн нь шүүхийн шийдвэрийн "захирамж" хэсэгт шууд тусгагддаг хэлбэр.
Хавсарсан хэм хэмжээний хяналт (inzidente Normenkontrolle)	Хэм хэмжээний акт хүчин төгөлдөр эсэх, хуульд нийцсэн эсэх нь тухайн үндсэн маргааныг шийдвэрлэхийн тулд урьдчилан шийдэх асуудал болох бөгөөд уг хэм хэмжээг тухайн хэрэгт хэрэглэж болох эсэх нь шүүхийн шийдвэрийн "үндэслэл" хэсэгт тусгагдана.
2. Хяналт хийгдэх процессын эх үүсвэр, процедурын шалтгааныг харгалзсан ангилал	

34 Schenke, W.-R, *supra* note 33, 401.

35 강지웅, *supra* note 13, 101.



Конкрет (бодит) хэм хэмжээний хяналт (konkrete Normenkontrolle)	Тодорхой нэг хэрэг маргааны явцад хэм хэмжээний актын хүчин төгөлдөр эсэх, хуульд нийцсэн эсэх нь урьдчилан шийдэх асуудал болох тул шүүх уг хэм хэмжээг хянаж үздэг хэлбэр.
Абстракт (хийсвэр) хэм хэмжээний хяналт (abstrakte Normenkontrolle)	Аль нэг тодорхой хэрэг маргаантай холбоогүйгээр, хэм хэмжээний акт хүчин төгөлдөр эсэх, хуульд нийцсэн эсэхийг бие даан шүүхээр шууд хянуулдаг хэлбэр.

Мөн VwGO §47.2-т "нэхэмжлэл гаргах эрх"-ийг шаарддаг тул субъектив эрхэд тулгуурласан маргааны шинжийг ч агуулдаг. Гэхдээ:

- захиргааны байгууллага өөрөө нэхэмжлэгч байж болох;
- үндсэн маргааны хүрээнд зөвхөн маргаантай хэм хэмжээний актын хүчин төгөлдөр байдал, хуульд нийцсэн эсэхийг шалгадаг;
- хяналтын шалгуур нь нэхэмжлэгчийн хувийн ашиг сонирхлыг хамгаалдаг "хамгаалах хэм хэмжээний онол"-оор (Schutznormtheorie) хязгаарлагддаггүй гэсэн шалтгаануудын улмаас энэ ажиллагаа нь илүү хүчтэй "объектив" маргааны шинжийг илэрхийлдэг.

Хэм хэмжээний хяналтын ажиллагаанд маргааны гол объект нь зөвхөн маргаантай хэм хэмжээний акт хуульд нийцсэн эсэхээр хязгаарлагдана. Энэ нь нэхэмжлэгчийн эрх зөрчигдөх эсэхтэй холбогдохгүй. Нэхэмжлэгчийн эрх зөрчигдөх боломжтой эсэхийг зөвхөн үндсэн маргаанаас өмнөх шатанд үнэлнэ. Өөрөөр хэлбэл, хэм хэмжээний актын хяналт нь зөвхөн тухайн хэм хэмжээний актын нөлөөнд өртсөн хувь хүний эрхийг хамгаалахаас гадна, цаашлаад эрх зүйн тогтвортой байдлыг хангах, хэм хэмжээний хэрэглээний нэгдмэл байдлыг бэхжүүлэх онцгой үүргийг биелүүлдэг.

VwGO §47.1-ийн 1 дэх заалт нь хэм хэмжээний актын хяналтын объект болох хэм хэмжээнд "Барилгын тухай хууль (Baugesetzbuch)-ын дагуу батлагдсан дүрэм (Satzung) болон Барилгын тухай хуулийн 246.2-т үндэслэсэн журмууд хамаарахаар заасан байдаг. Үүнд дараах хэм хэмжээний актууд хамаарна:

- Барилга төлөвлөлт (Bebauungsplan) — BauGB §10,
- Гадаад дүр төрхийг өөрчлөхийг хориглох дүрэм — BauGB §16,
- Урьдчилсан худалдан авах эрхийг бий болгох тухай дүрэм — BauGB §25,
- Хөгжлийн төлбөрийн журам — BauGB §132 зэрэг орно.³⁶

Дараагийнх нь, VwGO §47.1-ийн 2 дахь хэсэгт хэм хэмжээний актын хяналтын өөр нэгэн объект болох хэм хэмжээг "муж улсын хуулиас доод түвшний хэм хэмжээний акт" гэж тодорхойлдог. Зөвхөн муж улсын хуульд "тухайн хэм хэмжээний актыг хяналтын объект болно" гэж тусгайлан заасан тохиолдолд энэ ажиллагааны хүрээнд хянагдана.

Хэм хэмжээний хяналтын ажиллагаанд нэхэмжлэл гаргах эрхийн талаар VwGO §47.2-ийн эхний өгүүлбэрт "хэм хэмжээний акт, түүний хэрэглээний

³⁶ 강지웅, *supra* note 13, 102–104.

улмаас эрх нь зөрчигдсөн эсхүл ирээдүйд эрх нь зөрчигдөж болзошгүй гэж үзэж буй аливаа хувь хүн, хуулийн этгээд, түүнчлэн аливаа төрийн байгууллага гомдол гаргаж болно" гэж заасан байдаг. Иймд бусад төрлийн захиргааны маргаантай адил зарчмаар, маргаантай хэм хэмжээний актын улмаас эрх нь зөрчигдсөн, эсхүл ойрын хугацаанд зөрчигдөх бодит магадлалтай гэж үндэслэн мэдүүлж буй иргэн, хуулийн этгээд нь нэхэмжлэл (өргөдөл) гаргах эрхтэй гэж үзнэ.

Нөгөөтээгүүр, захиргааны байгууллагын хувьд иргэн, хуулийн этгээдээс ялгаатай нь хуульд ямар нэгэн тодорхой хязгаарлалтын заалт байхгүй бөгөөд "бүх захиргааны байгууллага" гэж заасан байдаг. Захиргааны байгууллагыг нэхэмжлэгчээр оролцуулах зорилго нь зарим тохиолдолд захиргааны байгууллага иргэдээс илүүтэйгээр нийтийн ашиг сонирхлын үүднээс нэхэмжлэгчийн үүргийг илүү үр нөлөөтэй хэрэгжүүлж чадна гэсэн санаанд тулгуурладаг байна. Иймд маргаантай хэм хэмжээний актын хэрэгжилттэй холбоотой үйл ажиллагаа эрхэлдэг, эсхүл тухайн хэм хэмжээг мөрдөх үүрэг бүхий захиргааны байгууллага л нэхэмжлэгч байж болно гэж шүүхийн практикт тайлбарладаг байна.³⁷

Хяналтын объект болох хэм хэмжээний акт нь зөвхөн тодорхой бус олон тохиолдолд хэрэглэх зохицуулалт байх бөгөөд үүнд нийтлэг хууль³⁸ болон бичигдээгүй хууль, захиргааны байгууллагын дотоод дүрэм журам хамаарахгүй.

Хүснэгт 3. Хэм хэмжээний актад хяналт хийлгэх өргөдлийг шалгах бүтэц

I. Хэм хэмжээний актыг хянуулах өргөдлийн зөвшөөрөгдөх байдал

1. Өргөдөл гаргах үндэслэлтэй эсэх
2. Хэм хэмжээний актын хяналт эхлүүлэх боломжтой эсэх
3. Өргөдөл гаргагчийн эрх зүйн чадвар
4. Өргөдөл гаргах эрх
5. Хариуцагч
6. Эрхийн хамгаалалт шаардлагатай эсэх (хэм хэмжээний хяналт шаардах бодит хэрэгцээ)
7. Өөр шүүхээр хэрэг хянан шийдвэрлэгдэх боломжгүй байх
8. Өргөдөл гаргах хугацаа

II. Хэм хэмжээний актын хяналтын үндэслэл

1. Шалгах ёстой зөрчил, маргаантай заалт
2. Хэлбэрийн хувьд хуульд нийцэж байгаа эсэх
3. Агуулгын хувьд хуульд нийцэж байгаа эсэх
4. Зөрчил тогтоогдсон тохиолдолд гарах эрх зүйн үр дагавар

Хэм хэмжээний актын хяналт зөвшөөрөгдөх нөхцөл нь шийдвэр гаргах этгээд (шүүх)-ийн эрх хэмжээний дагуу хэм хэмжээг хүчингүй болгоход чиглэсэн нэхэмжлэл юм. Мөн тухайн хэм хэмжээг хэсэгчлэн хүчингүй болгох эсхүл "хийдлийг засах хүртэл түр түдгэлзүүлэх" шийдвэр гаргах боломжтой байдаг. Онцгой тохиолдолд хууль бус хэм хэмжээний акт хүчин төгөлдөр байж болох

³⁷ Ibid 103.

³⁸ Ёс заншил буюу хэвшил болон тогтсон хууль.



бөгөөд энэ тохиолдолд зөвхөн хууль бус болохыг тогтоолгох нэхэмжлэлийн шаардлага гаргах эсрэгээрээ аль хэдийн хүчингүйд тооцсон хэм хэмжээний актыг хянуулах тохиолдолд, тухайн хэм хэмжээний акт хууль бус байсан гэдгийг тогтоолгох зорилготой байна.³⁹

Дээрхээс үзэхэд, VwGO §47-ийн дагуу хэрэгжүүлэх ажиллагааны зорилго нь зөвхөн нэхэмжлэгчийн эрхийн зөрчлийг арилгах төдий бус, тухайн хэм хэмжээг бүхэлд нь болон хэсэгчлэн хүчингүй болгоход чиглэдэг. Энэ агуулга нь мөн зөрчигдөж болзошгүй эрхийн хүрээнд адил хэрэглэгдэх зохицуулалт бөгөөд нэхэмжлэгчийн эрхийг хамгаалахаас гадна нийтлэг эрхийн баталгааг бий болгох өргөн хүрээний ач холбогдолтой. Иймд хэм хэмжээний актын хяналт нь эрхийн хамгаалалт болон эрхийн баталгааг бүрэн хангах онцлогтой эрх зүйн хэрэгсэл гэж дүгнэж болно.

Шүүхийн хяналтын үр дүнд маргаантай хэм хэмжээний акт нь хуультай зөрчилдөж байна гэж үзвэл, шүүх тухайн хэм хэмжээний актыг "хүчин төгөлдөр бус" гэж зарлана. Ийнхүү хүчин төгөлдөр бус гэж зарласан шийдвэр бүх хүнд, бүх байгууллагад хүчин төгөлдөр үйлчлэх нь хэм хэмжээний актын хяналтын объектив шинж хамгийн тод илэрдэг хэсэг юм.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

ЗХХА-д урьдчилсан хяналт хэрэгжүүлэх боломжийг "зөрчигдөж болзошгүй эрх"-ийн хүрээнд хуульчилсан явдал нь Монгол Улсын захиргааны эрх зүйн хөгжилд чухал нөлөө үзүүлсэн, иргэний эрхийг зөрчигдөхөөс өмнө хамгаалах тогтолцооны суурь тавигдсан бодит ололт гэж үзэх үндэслэлтэй. Энэ нь зөвхөн эрх зөрчигдсөний дараах нөхөн хамгаалалтад тулгуурлаж ирсэн уламжлалт механизмаас нэг алхам урагшилж, эрсдэл, хохирол үүсэхээс өмнө шүүхийн хяналтыг хэрэгжүүлэх эрх зүйн шинэ ойлголтыг бий болгоод зогсохгүй, шүүхийн практик болон тогтсоныг тэмдэглэх нь зүйтэй. Дүн шинжилгээний онол болон харьцуулсан судалгаанаас гарсан үр дүнг дүгнэхэд "зөрчигдөж болзошгүй эрх"-ийн хүрээнд ЗХХА-д шүүхээс урьдчилсан хяналт хэрэгжүүлэх нь объектив эрхийн хяналтын нэг хэлбэр бөгөөд ХБНГУ болон Монгол Улсын хувьд ЗХХА-ын улмаас эрх зөрчигдөхөөс өмнө шүүхэд хандах боломжийг адил үзэл санаанд тулгуурлан хуульчилж, баталгаажуулжээ.

Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын хувьд ЗХХА-ын хяналт, нэхэмжлэлийн шаардлага гаргах агуулга ч манай улсынхтай харьцуулахад өргөн хүрээнд тодорхойлогдсон байдаг. Нөгөөтээгүүр, Монгол Улсад ЗХХА-ын хяналт харьцангуй шинээр төлөвшиж буй ойлголт хэвээр байгаа бөгөөд нэхэмжлэлийн шаардлага гаргах боломж, хүрээг хуульд хязгаарлагдмал байдлаар тусгасан байна. ЗХХА-д холбогдох шүүхийн хяналтын цар хүрээг тэлж, нэхэмжлэл гаргах боломжийг илүү нээлттэй болгох нь субъектив эрхийн маргаанд хязгаарлагдахгүйгээр, нийтлэг хууль ёсны байдлыг хангах, шүүхийн хяналтын тогтолцоог бодитоор бэхжүүлэх алхам болно.

³⁹ Schenke, W.-R, *supra* note 33, 407.



Дүн шинжилгээгээр сонгон авсан УДШ-ын 2022 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 001/ХТ2022/0030 тогтоол нь ЗХХА-ын шинж болон онцлогоос хамаарч иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны эрх, ашиг сонирхол нь хэдийд ч зөрчигдөж болзошгүй гэж тодорхойлсон бөгөөд энэ тохиолдолд шүүхэд хандан "урьдчилсан хамгаалалт (хяналт)" хийлгэх зорилгоор нэхэмжлэл гаргах эрхийг баталгаажуулж өгсөн чухал ач холбогдолтой.



НОМ ЗҮЙ

1. Эрх зүйн эх сурвалж

1. Захиргааны ерөнхий хууль 2015 он.
2. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль 2016 он.
3. Үнэт цаасны бүртгэлийн журам 2021 он.
4. Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдааны 2023 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 30 дугаар тогтоол.
5. УДШ-ийн 2019 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 295 дугаар тогтоол.
6. Улсын дээд шүүхийн 2022 оны 3 дугаар сарын 01-ны өдрийн 001/ХТ2022/0030 тогтоол.
7. Улсын дээд шүүхийн 2022 оны 10 дугаар сарын 03-ны өдийн 001/ХТ2022/0056 тогтоол.
8. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2022 оны 03 сарын 01-ний өдрийн 221/ШШ2022/003 дугаар магадлал.
9. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 221/ШШ2022/0017 магадлал.
10. Захиргааны ерөнхий хуулийн үзэл баримтлал, 2015 он.

2. Монгол хэл дээрх эх сурвалж:

1. Гочоогийн Банзрагч, *Захиргааны процессын эрх зүй*, 2023 он.
2. Дугарын Сүнжид, *Захиргааны ерөнхий хууль: үзэл баримтлал, хэрэглээ*, 2017 он.
3. Цэндийн Цогт, Бат-Эрдэнийн Буянхишиг, Ганхуягийн Давааням, Баттулгын Дөлгөөн, *Захиргааны хэм хэмжээний акт*, 2025 он.
4. Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академи, *Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Захиргааны хэрэг шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль*, 2025 он.
5. Цэндийн Цогт, "Захиргааны хэм хэмжээний акт", *legaldata.mn*, 2016 он.

3. Гадаад хэл дээрх эх сурвалж:

1. Bundesrepublik Deutschland (1975). Entwurf eines Gesetzes zur Änderung verwaltungsprozessualer Vorschriften (Bundestags-Drucksache 7/4324, 21 November 1975),
2. Deutscher Bundestag (1958). Entwurf einer Verwaltungsgerichtsordnung (BT-Drs. 3/55).
3. Engelhardt, O.-R. B. von. (1971). Der Rechtsschutz gegen Rechtsnormen.
4. Schenke, W.-R. Verwaltungsprozessrecht (행정소송법), (강현호, Trans.), 홍지기법률연구재단 (2018).
5. 강지웅, "행정소송에서 민사소송법의 준용에 관한 연구-독일 행정소송과 우리 행정소송의 비교를 중심으로" (2023).



4. Цахим эх сурвалж

1. Монгол Улсын эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: <https://legalinfo.mn/mn>.
2. Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан: <https://shuukh.mn/>.
3. Хууль зүйн судалгааны бүтээлийн цахим сан: <https://legaldata.mn/>.
4. ХБНГУ-ын парламентын цахим хуудас: <https://www.bundestag.de/>.
5. ХБНГУ-ын судалгааны бүтээлийн цахим хуудас: <https://www.duncker-humblot.de/>.
6. Сөүлийн их сургуулийн цахим хуудас: <https://s-space.snu.ac.kr>.